

СЗМ – ТА ЗБЭДХ – Голомт Банк Зээл I

Байршил:	МОНГОЛ
Төслийн дугаар:	55935
Бизнесийн салбар:	Хадгаламжийн зээл (банк)
Мэдэгдлийн төрөл:	ХУВИЙН ХЭВШИЛ
Байгаль орчны ангилал:	Санхүүгийн байгууллага (СБ)
Батлагдсан огноо:	2025 оны 8 дугаар сарын 22
Төлөв:	Батлагдсан
Англи хэлээр нийтэлсэн огноо:	2025 оны 9 дүгээр сарын 1
	Мэдээлэл олж авах тухай удирдамжийн 1.4.2 (iii) хэсгийн дараахь заалтын дагуу: "Захирлуудын Зөвлөлөөс зөвшөөрөл олгох эрхээ шилжүүлсэн Банкны удирдлагын баталсан төслүүдийн хувьд ЕСБХБ үүсгэн байгуулах тухай Хэлэлцээрийн 13 (iii) дахь зүйлд заасны дагуу Банкны гишүүн улсад үл татгалзах тухай мэдэгдэл явуулах тухайн хугацааны эхэнд Төслийн хураангуй тойм баримт бичгийг ил нийтэлнэ."

Төслийн танилцуулга

Санхүүгийн зуучлалын механизм (СЗМ)-аар хэрэгжих Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр (Төв Азийн ЗБЭДХ)-ийн хүрээнд Голомт банк ХК (ГБ)-нд олгох 8 сая ам.доллар хүртэлх хэмжээний, анхдагч өглөгт тооцогдох 3 жилийн зээл.

Төслийн зорилго

Төв Азийн ЗБЭДХ-ийн Бодлогын мэдэгдэлд заасан нөхцөл хангах шалгууруудын дагуу 35 хүртэлх насны залуу хүмүүсийн удирддаг, нөхцөл хангасан бичил, жижиг, дунд бизнес (Залуучуудын БЖДҮ)-т дамжуулан зээлдүүлэхэд ЕСБХБ-ны зээлийн хөрөнгийг ашиглана. Түүнээс гадна, ГБ нь Төв Азийн ЗБЭДХ-т хамрагдан зээл авсан залуучуудыг жендэрээр ангилан бүртгэж, нийт дэд зээлдэгч нарын дор хаяж 30 хувь нь эмэгтэй байх явдлыг хангах үүрэг авсан.

Шилжилтийн нөлөөлөл

Хүлээгдэж буй шилжилтийн нөлөөлөл (ETI)-ийн оноо: 71

Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийн хөтөлбөрийн хүрээнд санал болгож буй тус төсөл Төв Азийн ЗБЭДХ-ийн зорилгыг хангахад хувь нэмэр оруулж, түүний *Хүртээмж* (анхдагч), *Өрсөлдөх чадвар* (хоёрдогч) гэсэн чанаруудыг дэмжиж ажиллана. Төсөл нь Залуучуудын БЖДҮ-т олгох зээлийг нэмэгдүүлж, ГБ-ны чадавхийг дэмжин, тус орны залуу бизнес эрхлэгчид, менежерүүдэд ур чадвар суулгах ажилд тус дэм болно гэсэн хүлээлттэй байна.

Үйлчлүүлэгчийн тухай мэдээлэл

ГОЛОМТ БАНК ХК

Шинэ үйлчлүүлэгч болох Голомт банк ХК (“ГБ”, эсвэл “Голомт”) нь Монголын арилжааны хоёр дахь том банк бөгөөд нийт хөрөнгө нь 4.5 тэрбум ам.доллар, зээлийн багц нь 2.1 тэрбум ам.доллар, үндсэн хөрөнгө нь 418 сая ам.доллар болж, 2024 оны эцсийн байдлаар зах зээлийн 21.6 хувийг эзэлж байна. Тус Банк өнөөдрийн байдлаар Moody’s компаниас B2/Тогтвортой, S&B болон Fitch компаниас B+/Тогтвортой гэсэн үнэлгээ аваад байна.

ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм

8,000,000.00 ам.доллар

8 сая ам.долларын анхдагч өглөгт тооцогдох зээл.

Төслийн нийт өртөг

8,000,000.00 ам.доллар

\$8 сая.

Нэмэлт ашиг тус

Санхүүгийн инновацлаг бүтэц ба/буюу хэрэгсэл: Төсөл нь Төв Азийн зах зээлийн онцлогт тохируулсан, инновацлаг хэрэгсэл болох Гүйцэтгэлд суурилсан нөхөн олговор (ГСНО) гэдэг санаачилгын ашиг тусыг хүртэх болно.

Санхүүжилтийн бүтэц: ЕСБХБ зах зээл дээр тэр болгон амар олддоггүй таатай нөхцлөөр дотоод валютын санхүүжилт олгоно.

Стандарт тогтоох: Төв Азийн ЗБЭДХ нь төслийн элементүүд (санхүүжилт, ГСНО, ТХА)-ийг нэгтгэн ашиглах замаар, залуу энтрепренерүүдийн орхигдсон хэсгийн хэрэгцээг илүү сайн ойлгож мэдрэх явдлыг бий болгосны үндсэн дээр санхүүгийн хүртээмжтэй стандартаа дээшлүүлэхэд нь Голомт банкинд дэмжлэг үзүүлэх болно. Инновацлаг бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд чухал үүрэгтэй ЗБЭДХ-ийн ТХА-ны зөвлөхтэй хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлж байх нь бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох, хүргэх механизмаа залуу энтрепренерүүдийн хэрэгцээнд илүү нийцсэн байдлаар шинэчлэх, хөгжүүлэх боломжийг санхүүгийн түнш байгууллагуудад олгоно.

Жендэрийн хувьд УХААЛАГ: Монголын залуу энтрепренершип дэх жендэрийн тэгш бус байдал үргэлжилсээр байгаа асуудал дээр ГБ-нд олгох ТХА-ны зориулалтын төслийн шугамаар ажиллах бөгөөд уг төсөл нь залуучуудад зориулсан зээллэгт жендэрийн мэдрэмжтэй хандах хандлагыг хөгжүүлэхэд нь тус дэм болох юм. Ингэснээр залуучуудад хүрч ажиллах явдал нь эмэгтэй, эрэгтэй залуучуудын аль алинд нь хандсан байхаар зохион байгуулагдах боломжтой болох юм.

Мэдлэг, инновац, ба чадавхи бий болгох: Тус хөтөлбөрт Жижиг бизнест зөвлөгөө өгөх (ASB) төслийн багаар дамжуулан СТБ-ууд болон залуучуудын БЖДҮ-т зориулсан сургалт хийх, зөвлөгөө өгөх зэргийг багтаасан, чадавхи бий болгох өргөн хүрээний үйл ажиллагаа орж байгаа бөгөөд энэ нь дотоодын зах зээл дээр байхгүй байж болох мэдлэг, мэргэжлийн туршлагаас суралцаж, ашиг тусыг нь хүртэх боломжийг бүх талуудад олгоно.

Байгаль орчин, нийгмийн тойм

Санхүүгийн байгууллага (FI) ангилал (БОНБ 2019)-д багтаж буй. Голомт нь шинэ үйлчлүүлэгч бөгөөд ЕСБХБ-ны 2019 оны Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ) болон ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) 2, 4 ба 9, түүний дотор Үл зөвшөөрөх жагсаалт, Хяналтын жагсаалтыг дагаж мөрдөх шаардлагатай. Үйлчлүүлэгчээр байгаль орчин, нийгмийн нарийвчилсан үнэлгээны асуумж бөглүүлэх, түүнтэй хоёр талын шугамаар харилцах замаар нарийвчилсан үнэлгээ хийж дууссан. Үйлчлүүлэгч одоогийн байдлаар ОУСК-тай харилцан ажиллаж байгаа бөгөөд тиймээс ч байгаль орчин, нийгмийн эрсдлүүдийг үнэлж цэгнэх, удирдан зохицуулах байгаль орчин, нийгмийн эрсдлийн менежментийн чадавхитай болсон. Гэхдээ, ГШ 2-ыг бүрэн дагаж мөрдөх, ЕСБХБ-ны хөрөнгийг ашиглан санхүүжүүлж буй бүх дэд төсөл дээр Үл зөвшөөрөх жагсаалт, Хяналтын жагсаалтыг хэрэгжүүлэх явдлыг хангах талаар зарим нэг шинэчлэл хийх шаардлагатай болно. ЕСБХБ-наас дэмжиж байгаа дэд төслүүд нь байгаль орчин, нийгмийн эрсдэл багатай байх хүлээлттэй бөгөөд худалдааны санхүүжилт, ЖДҮ-ийн зээллэг дээр төвлөрч ажиллах юм. Голомтын одоогийн байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоо нь байгаль орчин, нийгмийн эрсдлийн түвшинд нь тохирч байгаа бөгөөд түүнийг үр дүнтэй ашигладаг байх шаардлагатай. Голомт бас худалдааны санхүүжилт, ЖДҮ-ийн зээллэгтэй холбоотой БОН-ийн эрсдлүүдийг ангилах, үнэлэх, саармагжуулах, хянах талаар ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн эрсдлийн менежментийн удирдамжид нийцүүлж ажиллах хэрэгтэй. Голомт банк БОН-ийн жил бүрийн тайлангаа ЕСБХБ-нд хүргүүлж байх шаардлагатай. Голомтын зээлээр санхүүжилт авсан дэд зээлдэгчид үндэсний байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн шаардлагуудыг хангаж ажиллах ёстой.

Техник хамтын ажиллагаа ба Буцалтгүй тусламжийн санхүүжилт

Төв Азийн ЗБЭДХ-т ТХА-ны хоорондоо уялдаатай хоёр бүрэлдэхүүн хэсэг багтаж байна.Үүнд:

(i) Оролцогч санхүүгийн байгууллагуудад онцлогт нь тохируулсан чадавхи бий болгох:

Санхүүжилтийн эх үүсвэр: Хувьцаа эзэмшигчдийн тусгай сан (SSF) ба Япон;

Дүн/валют: 3.44 сая евро, Төв Азийн ЗБЭДХ-ийн түвшинд;

Санхүүжилтийн төлөв: Нотлогдсон.

Үйлчлүүлэгчийн хувь зардал: Голомт банк ТХА-ны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 10,000 хүртэлх евроны “зэрэгцээ” хувь зардал гаргаж, семинар, арга хэмжээ, маркетингийн үйл ажиллагаанд болон сургалт зохион байгуулах болон ЗБЭДХ-тэй холбоотой бүтээгдэхүүн сурталчлах ажилд ашиглах материалын зардалд зарцуулна гэсэн хүлээлттэй байна.

(ii) **ASB төслөөр дамжуулан, Залуучуудын БЖДҮ-ийн чадавхи бий болгох:**

Санхүүжилтийн эх үүсвэр: Хувьцаа эзэмшигчдийн тусгай сан (SSF);
Дүн/валют: 6 сая евро, Төв Азийн ЗБЭДХ-ийн түвшинд;
Санхүүжилтийн төлөв: Нотлогдсон.

Компаний холбоо барих мэдээлэл

Хатагтай Энхзаяа Баярсайхан, Олон улсын банкинг хариуцсан захирал

enkhzaya_b@golomtbank.com

+976 7575-1111 /1553/

+976 11-313155

<https://golomtbank.com/en>

Голомт банкны Төв байр, Д. Сүхбаатарын талбай 5, Шуудангийн хайрцаг 22,
Улаанбаатар 15160, Монгол Улс

ТХТ-ыг хамгийн сүүлд шинэчилсэн

2025.09.01

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авалт](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#), эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)-ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт](#), хянан шалгуулах хүсэлт тавих бол [Хүсэлт](#) хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.